

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛЭГЭЭ, ДОТООД АУДИТЫН ХЭЛТСИЙН
ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

САЙНЦАГААН СУМ

2020.12.24

№	Зөвлөмж	Хэрэгжилт	Хувь
1	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг гаргаж ирүүлэхдээ Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, өөрийн үнэлгээг хүснэгтээр нэгтгэн, хянаж, баталгаажуулсан гарын үсэгтэйгээр тайлангийн танилцуулгын хамт холбогдох хэлтэс болон ХШҮДАХэлтэст заасан хугацаанд хүргүүлэх	Засаг даргын зөвлөлийн хурлаар аймаг, сумын ЗДҮАХөтөлбөр, ЭЗНХҮЧиглэлийн хэрэгжилт, тогтоол шийдвэрийн биелэлт, иргэдээс ирүүлсэн санал өргөдөл гомдлын шийдвэрлэлтийг хэлэлцүүлэн, холбогдох зөвлөмжийг тусгалаа.	100
2	Ажилтнуудын сэтгэл ханамжийн санал асуулгыг тодорхой хугацаанд тогтмол хийх	Албан хаагчдаас судалгааг 2 төрлийн асуумжаар 2 удаа авлаа. Байгууллагын 36 албан хаагчдаас 4 бүлгийн 27 асуулгаар сэтгэл ханамжийн судалгаа авлаа. Судалгаанаас харахад боломжийн ур чадвартай албан хаагч 53.40%-ыг эзэлж байна.	100
3	Сумын ЗДҮАХөтөлбөр, ЭЗНХҮЧиглэл төлөвлөгөөний хэрэгжилтүүдийг хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4, 16 дугаар зүйлийн 16.3 дахь заалтуудыг үндэслэн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн, тоон үнэлгээгээр дүгнүүлж, тайлангийн хамт ирүүлэх	Засаг даргын бүрэн эрхийн хугацааны сумын ЗДҮАХөтөлбөрийн 39 заалтын хэрэгжилт 81.59%, ЭЗНХҮЧиглэлийн 70 заалтын хэрэгжилт -82.96%-тай тус тус үнэлэгдлээ. Цаг үеийн байдлаас шалтгаалан хийгдээгүй 8 ажил арга хэмжээ байна.Шинээр бүрдсэн сумын ИТХурлаар хэлэлцүүлэхээр болоод байна.	70
4	Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтэд тавих хяналтыг улирал бүр хийх, шалгуур үзүүлэлт бүрийн мэдээллийг бэлтгэх хариуцагчийг эзэнжүүлэх, дүн шинжилгээний ажлыг тогтмолжуулах	Үйл ажиллагааны болон хүний нөөцийн ил тод байдлын 14 шалгуур үзүүлэлтийг албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг тооцлоо.	70
5	Хэрэглэгчийн үнэлгээг бодитой хийлгэж, иргэдээс гарсан саналыг төлөвлөлтөндөө тусган үр дүнг тухайн ондоо багтаан тайлагнаж хэвших	Хэрэглэгчийн үнэлгээг ЗДТГазраас үйлчилгээ авч байгаа иргэдээс цаасаар авч нэгтгэлээ.Бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан нийтийг хамарсан арга хэмжээ явагдаагүй тул үнэлгээ иргэдээс авах ажил хийгдээгүй.	70
6	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх чиглэлээр урт хугацааны тогтвортой хяналт, урьдчилан сэргийлэх ажил болгох талаар байгууллагын зүгээс анхаарч ажиллах	Байгууллагын албан хаагчдыг ЭХО оношлогоонд бүрэн хамруулж,төлбөрийг байгууллагаас шийдвэрлэлээ. КОВИД-19 өөс урьдчилан сэргийлэх,албан хаагчдынхаа дархлааг дэмжих зорилгоор амны хаалт,халууны шил, аарц, чацаргана, нэг удаагийн хувцас хэрэглэлийг олгож, нийт 1345040 төгрөг зарцуулсан байна.Өглөө бүр албан хаагчдын	100

		халууныг хэмжиж, тэмдэглэгээ хийж байна.	
7	Нэг албан тушаал дээр тогтвортой ажиллаж буй боловсон хүчний үзүүлэлтийг судалж, дутагдалтай боловсон хүчний судалгаа гарган, хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах талаар бодлого барин ажиллах ба хүний нөөцийг бүрдүүлэхэд онцгой анхаарах	Тус сумын ЗДТГазрын албан хаагчдын ажилласан жилийн судалгааг гаргалаа. Нийт 40 албан хаагч ажилладаг ба тэдний 32.5 хувь нь тухайн албан тушаалдаа 5 хүртэл жил, 25 хувь нь 6-10 жил, 12.5 хувь нь 11-15 жил, 30 хувь нь 16-аас дээш жил ажилласан байна. Албан хаагчдын тогтвор суурьшилтай ажиллалаа.	100
8	Аймгийн болон сумын дэд хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжилт, гарсан үр дүн болон бусад холбогдох чиглэлээр өмнөх жилүүдтэй харьцуулсан судалгаа, дүгнэлт гаргаж, явц, үр дүнд хяналт тавин, чиглэл өгөх	Боловсрол хөгжил-98%, Математик-95%, байгалийн ухаан-95%, Үндэсний бичиг-95%, Хүүхдэд ээлтэй дотуур байр-94% хэрэгжүүллээ. Сумын ЕБСургуулиудад “Чадвартай багш-Чанартай боловсрол-2” дэд хөтөлбөрийг хэрэгжүүллээ.	100
9	“Эрүүл иргэнтэй-Дундговь” хөтөлбөрийн хүрээнд дорвитой ажил, арга хэмжээ зохион байгуулж, үр дүнг тооцон ажиллах	ЭМС-ын А/472 тоот тушаалын дагуу Эрүүл мэндийг дэмжигч байгууллага, өрх шалгаруулах журмын дагуу хөдөөгийн 4 багаас эрүүл мэндийг дэмжигч өрхийг шалгарууллаа. Нийт 8 өрхийн үнэлгээнд шалгуурлалт хийж 4 өрхийг “Эрүүл мэндийн дэмжигч өрхөөр Наран баг- Зундуйнжамц Бямбаа, Тэвш баг- Дүгэр Дугарсүрэн, Далай баг- Хавчуур Бүрэн-Амгалан, Үйзэн баг- Сугир Бат-Эрдэнэ нарыг шалгарууллаа. Сумын ОНХСангийн хөрөнгөөр сумын, өрхийн ЭМТөвүүдэд 20 сая төгрөгийн тоног төхөөрөмж, эмнэлгийн багаж хэрэгсэл олголоо. Нарлаг багт сайжруулсан ариун цэврийн байгууламж 2-ыг шинээр барилаа. Элэгний В, С шинжилгээнд-1202 иргэнийг хамруулж, 15% буюу anti-HCV эерэг -50, HBsAg эерэг-42, артерийн гипертенз илрүүлгийн үзлэгт 1473 буюу 50%, чихрийн шижин хэв шинж 2-т 1380 буюу 45%, хөхний хавдар илрүүлэх үзлэгт 1464 буюу 42%, умайн хүзүүний хавдар илрүүлэх PAP шинжилгээнд 644 эмэгтэй хамрагдаж 70,2%-тай байна.	70
10	Аймгаас дэвшүүлсэн зорилтын хүрээнд хийх ажлыг төлөвлөн хэрэгжилт үр дүнг хагас бүтэн жилээр тооцон тайланг холбогдох хэлтэст хүргүүлэх	Аймгийн засаг даргын 2020 оны 01 захирамжаар дэвшүүлсэн зорилтын хүрээнд 7 арга хэмжээ төлөвлөн 72,85 хувьтай хэрэгжүүллээ. Аймгийн төвд 2,8 км авто зам ашиглатанд орж, орон нутгийн чанартай авто замын хүчин чадал 20%-иар нэмэгдлээ. 5,12-р орон сууцны гадна дулаалга, 5, 9, 12, 13-р байрнуудын гадна тохижилт, тоглоомын талбайн байгуулснаар 4 байрны 144 айлын 576 орчим оршин суугчдын амьдрах таатай орчин бүрдсэн зэрэг үр дүнд хүрлээ.	70
11	Хариутай бичиг шийдвэрлэлтэд тавих хяналтыг сайжруулж, тайлан мэдээ хоцроосон албан хаагчдад хариуцлага тооцох	Сумын ЗДТГазарт 438 албан бичиг ирсэнээс хариутай 54 бичгийг хугацаанд нь шийдвэрлэгдлээ. ЗДТГазраас явсан 522 албан бичгийг стандартын дагуу гаргаж, хүргүүллээ.	100
12	Аймаг, сумын ОНХСангаар хийгдсэн гудамж, хорооллын гэрэлтүүлгийг асааж байнгын	“Мосума корпораци” ХХК –тай хамтран сумын ОНХС-ын 9 сая төгрөгөөр гоёлын 53 ш гэрлийг Нарлаг баг Буяннэмэхийн өргөн чөлөөний засмал зам	70

	ажиллагаатай болгох	дагуу хийлээ. Арвижих багийн 14 гудамжинд 222, Мандал багийн 13 гудамжинд 383, Айраг багийн 5 гудамжинд 164 нарны зайн цэнэглэгчтэй гэрэлтүүлэгчийн зураг, төсвийг холбогдох газарт хүргүүллээ.	
13	Хог зөөврийн талаар иргэдээс гарсан санал хүсэлтийн дагуу тодорхой арга хэмжээ зохион байгуулан, иргэдэд үр дүнг эргэж мэдээлэх	Энэ онд өөрийн биеэр-110, утсаар-400, цахимаар-53 гомдол, саналыг хуулийн хугацаанд шийвдэрлэлээ. Эдгээр 563 гомдол саналаас 70% нь хог хаягдал, 25% нь гэрэлтүүлэг, 5% нь тохижилт, үйлчилгээтэй холбоотой байна. 2021 онд аймгийн ОНХСангийн хөрөнгөөр хог тээврийн машин 5, бункер чирэгч, гэрэлтүүлэг засвар, зам талбайн цэвэрлэгээний машин тус бүр 1-ийг авч хог тээврийн хүчин чадлыг нэмэгдүүлэхээр ИТХурлаар төсвийг батлууллаа.	70
14	Аймгийн засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг 2.1.1-дэх заалтыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлж, жижиг дунд үйлдвэр байгуулахад СХСангийн хөрөнгийг чиглүүлэх	2020 онд аймаг, орон нутгийн бодлого зорилтын хүрээнд зах зээл түүхий эд, давуу талд түшиглэн ➤ Малын гаралтай дайвар бүтээгдэхүүн боловсруулах 2 ➤ Арьс нэхий боловсруулах ➤ Тавилгын үйлдвэр ➤ Бүх төрлийн бүрээс оёх зэрэг 5 жижиг үйлдвэрийг шинээр байгуулахад 147 сая төгрөгийн зээлийг олголоо.	70
15	СХСангийн зээлийн эх үүсвэрийг эдийн засагт жижиг, дунд үйлдвэрийн эзлэх байр суурийг бэхжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэхэд чиглүүлэх, олгосон зээлийн үр дүн, хэрэгжилтийг журмын дагуу хугацаанд нь тайлагнах	СХС-ийн тэргүүлэх чиглэлийн дагуу 4 чиглэлээр 9 төрлийн бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэн ААНэгжидэд олгосон зээлийн 7 төсөл нь тэдний тогтвортой байдлыг сайжруулахад дэмжсэнээр 26 ажлын байр хадгалагдаж, шинээр 69 байнгын болон түр ажлын байрыг бий болгосон нь өмнөх оноос 42 оор нэмэгдсэн үр дүнтэй байна.	100
16	Малын эрүүл мэндийн үзлэг, угаалга, боловсруулалт, сэг зэм устгал, хороо хашааны халдваргүйтгэлийг сумын хэмжээнд зохион байгуулах	Бруцеллёзын дархлаажуулалтанд богийн 46400 охин төлөөс 46275, 400 охин тугал хамрагдахаас 358 охин тугал нийт 46633 охин төл хамруулж 99,6%-тай байна. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 5 төрлийн дархлаажуулалт хийлээ.Үүнд:Шөвөг ярын дархлаажуулалтанд 20641 ишигнээс 17291 ишиг хамруулж 83,77%, ДХХ-энтеробактериоз хамын дархлаажуулалтанд 53680 бог малаас 42992 хамруулж 80,09%, галзуугийн дархлаажуулалтанд 2861 малаас 2415 ыг хамруулж 84,41%, дуутын дархлаажуулалтанд 1105 үхрээс 1187 үхэр хамруулж 107%, Сахуугийн дархлаажуулалтанд 796 унаганаас 892ыг хамруулж 112,06% гүйцэтгэлтэй ба нийт дүнгээр 64777 толгой малыг 93,6% хамрууллаа. Бруцеллёзын шинжилгээнд 275 хуц, 150 ухна нийт 425 хээлтүүлэгч хамрагдсанаас 7 хуц, 3 ухна эерэг /өвчтэй/ гарсан тул зааврын дагуу арга хэмжээ авлаа. Хөдөөгийн 4 багт болон аймгийн төв орчим, засмал зам дагуу 569 км явж	100

		нийт 821 үхсэн малын сэг зэмийг цуглуулж аймгийн төвлөрсөн хогийн цэгт булж ариутгал халдвагүйтгэлийг хийсэн. Мөн 32 өвөлжөө, 18 уст цэг, бэлчээрийн 11900 мкв талбайг ариутгасан. Сэг зэмийн устгалд 4 машинтай 16 малчинг дайчлан ажиллуулж 158620 төгрөгийн шатахуун зарцууллаа. Байгалийн гамшигт үзэгдлийн улмаас Төв аймгийн Сэргэлэн сумын нутагт /Довын хөндий/ оторлож явсан Тэвш багийн 3 өрхийн мал үерт өртсөнийг устгалыг 5*5 км талбайн 2100 орчим сэг зэмийг цуглуулж 2020 оны 06 сарын 26 нд төрийн албан хаагч 23, цэргийн дүйцүүлэх албан хаагч 9 иргэн, авто машин 7-г гарган 2100 орчим сэг зэмийг 2 хоногийн хугацаанд бүрэн устгал хийлээ. Энэ онд 32 өвөлжөө, хашаа хороог ариутгалаа.	
17	Улсын болон орон нутгийн хөгжлийн сан, гадаадын төсөл хөтөлбөрөөр хийгдэж байгаа ажлыг графикийн дагуу эрчимжүүлэх	Сумын ОНХСангийн хөрөнгөөр хийхээр төлөвлөсөн 10 ажил арга хэмжээнээс 9 ажил хэрэгжлээ. ОНХСангийн санхүүжилт хуваарийн дагуу орж ирээгүй, мөн цар тахлын улмаас худалдан авах ажиллагаа сангийн яамнаас хойшлуулсан зэрэг асуудлууд тулгарсан болно. Улсын төсвийн 3.8 тэр бум төгрөгний хөрөнгө оруулалтаар 6 барилга байгууламжийн ажил хийгдэхээс 1-р цэцэрлэгийн барилга ашиглалтанд орж, бусад ажлууд граффикийн дагуу хийгдэж байна.	100
18	ОНХСангийн удирдлагын системд мэдээллийг тухай бүр оруулах, ОНХСангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг олон нийтэд мэдээлэх	Сумын ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх ажлын мэдээллийг удирдлагын нэгдсэн санд оны эхэнд байршуулж, гүйцэтгэлийг тухай бүр орууллаа. ОНХСангийн хөрөнгөөр хийгдсэн ажлыг Сайнцагаан ЗДТГазрын пэйж хуудас болон Dundgovi.gov.mn сайтад байршуулан олон нийтэд мэдээллээ.	100
19	Сангийн сайдын 2019 оны 282-р тушаалаар батлагдсан журмын дагуу ОНХСангийн эх үүсвэрээр хийгдэж байгаа бараа, ажлын санхүүжилтыг гаргах, баримтын бүрдлийг хангах	Энэ онд сумын ОНХСангийн хөнөргөөр 9 ажил хийгдэж, 117.4 сая төгрөгний санхүүжилтийг журмын дагуу хяналтын хүснэгтэнд заасан баримт бичгийн бүрдлийг хангалаа.	100
Хэрэгжилтийн-87.36%			

ХЭРЭГЖИЛТ ГАРГАСАН:

САЙНЦАГААН СУМЫН

ЗДТГ-ЫН ДАРГА

Б.ОЮУНЧИМЭГ